



ТӨВ АЙМГИЙН  
БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 4/12

Борнуур

Сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн  
2022 оны худалдан авах ажиллагааны  
төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”- ийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар хуралдааны 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2022 онд хэрэгжүүлэх, бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Худалдан авах бараа, ажил үйлчилгээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, ажлын даалгаврыг, хуралдан авах ажиллагааг зохион байгуулах, үнэлгээний хороог, журамд заасны дагуу байгуулж, захиалагч байгууллагын эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Өлзийбуян) болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, холбогдох тайлан, мэдээг хууль, журамд заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг Санхүү албаны даргын албаны дарга (Н.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Чингис/, Хууль эрх зүйн мэргэжилтэн (С.Сарангэрэл) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.УНДРАХБИЛЭГ

0001 027